

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/6/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Баянхонгор хот 2024.03.25	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Ахлах аудитор: М.Алтантуяа Утас: 99442140 Аудитор: Б.Нарангэрэл Утас: 99009293 Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a>	Цахим хаяг: <a href="mailto:munkhbatb@audit.gov.mn">munkhbatb@audit.gov.mn</a> М.Алтантуяа Цахим хаяг: <a href="mailto:altantuyam@audit.gov.mn">altantuyam@audit.gov.mn</a> Б.Нарангэрэл Цахим хаяг: <a href="mailto:Narangerelb@audit.gov.mn">Narangerelb@audit.gov.mn</a>
--	--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

<b>1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ</b> .....	3
<b>2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	6
<b>3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА</b> .....	14
<b>3.4.1 Мөнгөн хөрөнгө</b> .....	15
<b>3.5.2 Авлага</b> .....	16
<b>3.5.4 Бараа материал</b> .....	16
<b>3.5.6 Үндсэн хөрөнгө</b> .....	17
<b>3.5.7 Өр төлбөр</b> .....	18
<b>3.5.10 Засгийн газрын хувь оролцоо</b> .....	18
<b>3.5.11 Орлогын данс</b> .....	19
<b>3.5.12 Зардлын данс</b> .....	20
<b>4. АУДИТЫН ТАЙЛАН</b> .....	26
<b>4.1 Ерөнхий зүйл</b> .....	26
<b>4.2 Материаллаг байдал</b> .....	27
<b>4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт</b> .....	27
<b>4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b> .....	27
<b>4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт</b> .....	28
<b>4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт</b> .....	28
<b>4.7.1 Завсрын аудитын талаар</b> .....	28
<b>5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	29
<b>5.1 Төлбөрийн акт</b> .....	29
<b>5.2 Албан шаардлага</b> .....	29
<b>5.3 Зөвлөмж</b> .....	30
<b>6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	31

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement\_bayankhongor@audit.gov.mn

2024.03.25 № 2/95

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2023оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бууцагаан сумын Засаг даргын тайланд нэгтгэгддэг 4 байгууллагаас сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд "Сөрөг" дүгнэлт өгч, 3 байгууллагыг үе шатны түүвэрт хамруулсан.

Тус аудитаар болон харьяа төсөвт байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчил нь төлөвлөлтийн шатанд урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн бөгөөд бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн нийт алдаа зөрчил нь гүйцэтгэлийн материаллаг байдлаас давсан;
- Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 487,426.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 120,989.0 мянган төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж, 12,754.3 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 256,105.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 97,207.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн;
- Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 5 зээлдэгчийн 11,236.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй;

D- alban bichig 2024 A4 TOOT

5020360

- Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 398.8 мянга, бууны татвар 300.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 37,527.1 мянга, түүгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 600.0 мянган төгрөгөөр тасарсан зэрэг зөрчлүүд илэрлээ.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8 "Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ", 23.9 "Сум, дүүргийн төсвийн татварын бус орлого дараах орлогоос бүрдэнэ", 41 дүгээр зүйлийн 41.1 дэх "Батлагдсан төсвийг хэрэгжүүлэх нарийвчилсан хуваарь, төсвийн дэлгэрэнгүй хуваарилалт, төсвийн зарцуулалт болон бүрдүүлэлтэд тавих хяналтыг төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийн дагуу хэрэгжүүлнэ", 41.2.7 дахь "Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах", гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын дүгнэлтийн үндэслэл болгосон дээрх зөрчил дутагдал нь бидний урьдчилан тогтоосон материаллаг байдлаас хэтэрсэн, аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалтыг ажил гүйлгээний хувьд хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

#### **Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Бууцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2023 оны биелэлтийг 94.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Бууцагаан сумын Засаг даргын санхүүгийн нэгтгэсэн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Сумын Засаг дарга санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

D- alban bichig 2024 A4 TOOT

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР

Б.МӨНХБАТ

D- alban bichig 2024 A4 TOOT

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>662,196.83</b>	<b>902,786.57</b>
<b>31</b>	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	<b>321,800.71</b>	<b>507,382.43</b>
<b>31200</b>	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	<b>321,800.71</b>	<b>507,382.43</b>
<b>31210</b>	<b>Төгрөг</b>	<b>321,800.71</b>	<b>507,382.43</b>
31211	Төрийн сангийн харилцах	321,800.71	507,382.43
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>190,821.69</b>	<b>252,453.44</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	741.90	742.38
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	10.00	10.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>0</b>	<b>36,180.00</b>
33520	Хувь хүмүүсээс авах авлага	0	36,180.00
<b>33600</b>	<b>Зээлийн авлага</b>	<b>190,069.79</b>	<b>215,521.06</b>
<b>33610</b>	<b>Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага</b>	<b>190,069.79</b>	<b>215,521.06</b>
33612	Хувь хүмүүст олгосон зээл	190,069.79	215,521.06
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>149,574.44</b>	<b>142,950.70</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>3,900.00</b>	<b>13,695.00</b>
35110	Тусгай зориулалттай материал	3,900.00	13,695.00
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>134,674.44</b>	<b>88,678.32</b>
35410	Бичиг хэргийн материал	4,154.84	4,417.34
35420	Аж ахуйн материал	1,852.90	0
35440	Түлш, шатах тослох материал	300.00	300.00
35450	Барилгын засварын материал	4,392.00	8,892.00
35470	Бусад хангамжийн материал	123,974.70	75,068.98
35600	Мал амьтад	11,000.00	40,577.38
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,142,505.80</b>	<b>2,105,643.59</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>2,142,505.80</b>	<b>2,105,643.59</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>2,124,505.80</b>	<b>2,087,643.59</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	4,736,867.23	4,788,862.18
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2,852,573.28	-3,102,316.21
39203	Авто-тээврийн хэрэгсэл	290,330.50	277,350.50
39204	Хуримтлагдсан элэгдэл	-235,069.82	-226,417.85
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	256,267.00	233,191.10
39206	Хуримтлагдсан элэгдэл	-187,266.77	-152,114.72
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	116,916.61	121,943.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	-97,043.73	-91,153.56
39209	Зам, гүүрийн байгууламж	0	27,000.00
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	7,000.00	7,000.00
39214	Бусад үндсэн хөрөнгө	152,111.82	277,874.72
39215	Хуримтлагдсан элэгдэл	-63,033.75	-73,575.71
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>18,000.00</b>	<b>18,000.00</b>
39301	Програм хангамж	13,978.00	13,978.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-13,978.00	-13,978.00
39303	Бусад биет бус хөрөнгө	18,000.00	18,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>2,804,702.63</b>	<b>3,008,430.16</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,575.23</b>	<b>2,143.36</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,575.23</b>	<b>2,143.36</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>6,575.23</b>	<b>2,143.36</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5.09	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,570.14	1,643.36
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>0</b>	<b>500.00</b>
41361	Байгууллагад төлөх өглөг	0	500.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,798,127.40</b>	<b>3,006,286.81</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>2,798,127.40</b>	<b>3,006,286.81</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	537,862.77	537,862.77
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	537,862.77	537,862.77
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,840,901.51</b>	<b>2,049,096.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	15,249,223.85	1,877,116.98
51220	Тайлант үеийн үр дүн	-13,408,322.34	171,979.41
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,363.12	419,327.64
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>2,804,702.63</b>	<b>3,008,430.16</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,565,502.63</b>	<b>2,601,170.73</b>
<b>11</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>453,273.85</b>	<b>637,385.33</b>
<b>110</b>	<b>Орлогын албан татвар</b>	<b>237,782.74</b>	<b>326,220.79</b>
<b>1100</b>	<b>Хувь хүний орлогын албан татвар</b>	<b>237,782.74</b>	<b>326,220.79</b>
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	179,330.57	250,234.76
110002	Үйл ажиллагааны орлого	20,199.07	25,919.64
110003	Хөрөнгийн орлого	34,020.23	46,258.19
110004	Хөрөнгө борлуулсны орлого	4,232.87	3,808.20
<b>113</b>	<b>Хөрөнгийн албан татвар</b>	<b>57,152.19</b>	<b>68,237.35</b>
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,232.12	1,484.45
113002	Бууны албан татвар	2,310.00	2,280.00
113004	Малд ногдуулах албан татвар	52,610.07	64,472.90
<b>118</b>	<b>Бусад татвар, төлбөр, хураамж</b>	<b>158,338.93</b>	<b>242,927.19</b>
<b>1180</b>	<b>Бусад нийтлэг төлбөр, хураамж</b>	<b>10,418.12</b>	<b>32,164.56</b>
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,654.82	10,916.03
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,133.30	0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,630.00	21,248.53
<b>1181</b>	<b>Газрын төлбөр</b>	<b>3,427.31</b>	<b>6,907.23</b>
118101	Газрын төлбөр	3,427.31	6,907.23
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>144,493.50</b>	<b>203,716.15</b>
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	142,565.32	203,008.88
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,928.18	707.28
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	<b>0</b>	<b>139.25</b>
118301	Бусад татвар	0	139.25
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>339,433.62</b>	<b>442,948.77</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>339,433.62</b>	<b>442,948.77</b>
120003	Торгуулийн орлого	29,426.00	83,680.88
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>68,900.00</b>	<b>12,187.11</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	68,900.00	10,717.35
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0	1,469.76
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	110,898.31	268,027.19
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	130,209.32	79,053.58
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,772,795.15</b>	<b>1,520,836.63</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>15,297.59</b>	<b>44,808.20</b>
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,297.59	44,808.20
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>104,830.86</b>	<b>34,641.33</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,540.00	0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,290.86	34,641.33
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,652,666.70</b>	<b>1,441,387.10</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	569,320.50	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	824,592.30	1,037,166.80
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	258,753.90	404,220.30
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,658,621.93</b>	<b>2,422,229.40</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,658,621.93</b>	<b>2,422,229.40</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,443,753.91</b>	<b>1,747,386.34</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>303,739.87</b>	<b>482,397.76</b>
210101	Үндсэн цалин	238,859.08	369,910.47
210102	Нэмэгдэл	38,765.00	112,487.29
210103	Унаа хоолны хөнгөлөлт	1,145.00	0
210104	Урамшуулал	5,524.80	0
210105	Гэрээт ажлын хөлс	19,446.00	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>38,547.18</b>	<b>60,116.37</b>
210201	Тэтгэврийн даатгал	25,794.19	40,892.41
210202	Тэтгэмжийн даатгал	3,224.58	4,811.03
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,707.33	3,848.76
210204	Ажилгүйдлийн даатгал	605.99	957.40
210205	Эрүүл мэндийн даатгал	6,215.08	9,606.76

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>34,513.50</b>	<b>45,517.98</b>
210301	Гэрэл, цахилгаан	7,463.48	12,420.52
210302	Түлш, халаалт	27,050.02	32,597.66
210303	Цэвэр, бохир ус	0	499.80
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>55,944.29</b>	<b>156,804.50</b>
210401	Бичиг хэрэг	3,190.06	4,292.83
210402	Тээвэр, шатахуун	49,170.58	71,432.34
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,469.20	4,759.80
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	960.00	9,936.96
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,154.45	6,436.55
210408	Бараа материал акталсны зардал	0	59,946.02
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>3,562.50</b>	<b>0</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,562.50	0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>72,875.82</b>	<b>11,958.20</b>
210604	Урсгал засвар	72,875.82	11,958.20
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4,224.00</b>	<b>6,540.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,960.00	6,540.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	264.00	0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>484,975.49</b>	<b>574,570.74</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	481,106.49	574,385.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27.00	0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82.00	0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,260.00	185.30
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>445,371.25</b>	<b>409,480.80</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	50,705.20	102,053.42
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,002.40	0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хоргодол	393,663.65	307,427.38
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,214,868.02</b>	<b>674,843.06</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,599.30</b>	<b>3,728.00</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	0	500.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,339.30	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260.00	3,228.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,190,268.72</b>	<b>671,115.06</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,183,092.70	670,830.90
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	7,036.77	0
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	139.25	284.16
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>-93,119.30</b>	<b>178,941.32</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>13,315,203.04</b>	<b>6,961.92</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	13,000,041.88	6,961.92
225011	Үнэ төлбөргүй гарсан зардал - Бараа материал	315,161.16	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>-13,408,322.34</b>	<b>171,979.41</b>

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,132,340.90	3,024,883.32	11,367,537.40	16,524,761.63
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	537,862.77	419,363.12	1,840,901.51	2,798,127.40
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,362.77	419,363.12	15,249,223.85	16,205,949.74
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-1,594,978.13	-2,605,520.21	3,881,686.44	-318,811.89
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	500.00	0	0	500.00
9	Тайлант үеийн үр дүн	0	0	-13,408,322.34	-13,408,322.34
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	537,862.77	419,363.12	1,840,901.51	2,798,127.40
20	2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	537,862.77	419,327.64	2,049,096.39	3,006,286.81
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	537,862.77	419,363.12	1,877,116.98	2,834,342.87
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	36,215.47	36,215.47
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-35.47	0	-35.47
19	Тайлант үеийн үр дүн	0	0	171,979.41	171,979.41

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,988,460.41	2,309,638.69
11	ТАТВАРЫН ОРЛОГО	453,273.85	637,385.33
110	Орлогын албан татвар	237,782.74	326,220.79
1100	Хувь хүний орлогын албан татвар	237,782.74	326,220.79
110001	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	179,330.57	250,234.76
110002	Үйл ажиллагааны орлого	20,199.07	25,919.64
110003	Хөрөнгийн орлого	34,020.23	46,258.19
110004	Хөрөнгө борлуулсны орлого	4,232.87	3,808.20
113	Хөрөнгийн албан татвар	57,152.19	68,237.35
113001	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	2,232.12	1,484.45
113002	Бууны албан татвар	2,310.00	2,280.00
113004	Малд ногдуулах албан татвар	52,610.07	64,472.90
118	Бусад татвар, төлбөр, хураамж	158,338.93	242,927.19
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,418.12	32,164.56
118001	Улсын тэмдэгтийн хураамж	4,654.82	10,916.03
118006	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	1,133.30	0
118009	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	4,630.00	21,248.53
1181	Газрын төлбөр	3,427.31	6,907.23
118101	Газрын төлбөр	3,427.31	6,907.23

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>1182</b>	<b>Байгалийн нөөц ашигласны төлбөр</b>	<b>144,493.50</b>	<b>203,716.15</b>
118202	Ан амьтны нөөц ашигласны төлбөр	142,565.32	203,008.88
118203	Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	1,928.18	707.28
<b>1183</b>	<b>Бусад татвар</b>	<b>0</b>	<b>139.25</b>
118301	Бусад татвар	0	139.25
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>148,619.21</b>	<b>151,416.73</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>148,619.21</b>	<b>151,416.73</b>
120003	Торгуулийн орлого	29,426.00	83,680.88
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>119,193.21</b>	<b>67,735.85</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	118,193.21	67,521.09
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	214.76
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,386,567.35</b>	<b>1,520,836.63</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>15,297.59</b>	<b>44,808.20</b>
131003	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,297.59	44,808.20
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>104,830.86</b>	<b>34,641.33</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	7,540.00	1,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	97,290.86	33,341.33
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>2,266,438.90</b>	<b>1,441,387.10</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,183,092.70	0
132006	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/	824,592.30	1,037,166.80
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	258,753.90	404,220.30
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,511,261.80</b>	<b>1,619,849.08</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,511,261.80</b>	<b>1,619,849.08</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,288,132.96</b>	<b>1,570,428.72</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>380,476.52</b>	<b>481,945.12</b>
210101	Үндсэн цалин	246,581.61	342,491.77
210102	Нэмэгдэл	38,334.80	139,453.35
210104	Урамшуулал	2,753.26	0
210105	Гэрээт ажлын хөлс	92,806.85	0
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>46,284.33</b>	<b>60,224.02</b>
210201	Тэтгэврийн даатгал	32,472.17	40,965.56
210202	Тэтгэмжийн даатгал	3,111.68	4,819.63
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,397.30	3,855.60
210204	Ажилгүйдлийн даатгал	695.43	959.16
210205	Эрүүл мэндийн даатгал	6,607.75	9,624.06
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>552,844.74</b>	<b>663,834.78</b>
210301	Гэрэл, цахилгаан	35,481.93	47,053.84
210302	Түлш, халаалт	510,581.20	607,093.24
210303	Цэвэр, бохир ус	6,781.60	9,687.70
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>52,664.49</b>	<b>89,319.94</b>
210401	Бичиг хэрэг	2,138.96	3,690.90
210402	Тээвэр, шатахуун	40,577.58	71,118.09
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,769.70	2,238.95
210404	Ном, хэвлэл	98.88	0
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	7,400.73	11,672.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	678.65	600.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,996.50</b>	<b>9,700.00</b>
210604	Урсгал засвар	4,996.50	9,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>3,461.00</b>	<b>7,543.00</b>
210702	Дотоод албан томилолт	3,461.00	7,543.00

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>104,986.40</b>	<b>83,182.24</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	100,739.15	78,533.24
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.00	500.00
210803	Даатгалын үйлчилгээ	44.25	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57.00	27.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	82.00	60.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,564.00	3,762.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	0	300.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>142,418.99</b>	<b>174,679.63</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	140,918.99	168,679.65
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,500.00	5,999.98
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,223,128.84</b>	<b>49,420.36</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>24,599.30</b>	<b>4,328.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	22,339.30	0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,260.00	4,328.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>1,198,529.54</b>	<b>45,092.36</b>
213401	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт төсөвт байгууллага	1,183,092.70	0
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	15,297.59	44,808.20
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	139.25	284.16
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>477,198.61</b>	<b>689,789.61</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>407,990.40</b>	<b>504,207.88</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>407,990.40</b>	<b>504,207.88</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>407,990.40</b>	<b>504,207.88</b>
220001	Барилга байгууламж	379,454.40	494,707.98
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	28,536.00	9,499.90
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-407,990.40</b>	<b>-504,207.88</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>69,208.20</b>	<b>185,581.73</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	252,592.50	321,800.71
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	321,800.71	507,382.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,249,847.60</b>	<b>2,044,607.44</b>	<b>205,240.16</b>	<b>90.9</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,656,094.80</b>	<b>1,549,899.45</b>	<b>106,195.35</b>	<b>93.6</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,620,425.20</b>	<b>1,545,571.45</b>	<b>74,853.75</b>	<b>95.4</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>482,096.80</b>	<b>481,945.12</b>	<b>151.68</b>	<b>100.0</b>
210101	Үндсэн цалин	342,520.30	342,491.77	28.53	100.0
210102	Нэмэгдэл	139,576.50	139,453.35	123.15	99.9

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>60,262.00</b>	<b>60,224.02</b>	<b>37.98</b>	<b>99.9</b>
210201	Тэтгэврийн даатгал	40,978.10	40,965.56	12.54	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	4,820.90	4,819.63	1.27	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,856.70	3,855.60	1.10	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	964.30	959.16	5.14	99.5
210205	Эрүүл мэндийн даатгал	9,642.00	9,624.06	17.94	99.8
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>714,805.00</b>	<b>663,834.78</b>	<b>50,970.22</b>	<b>92.9</b>
210301	Гэрэл, цахилгаан	59,974.90	47,053.84	12,921.06	78.5
210302	Тулш, халаалт	645,142.10	607,093.24	38,048.86	94.1
210303	Цэвэр, бохир ус	9,688.00	9,687.70	0.30	100.0
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>88,837.90</b>	<b>88,719.94</b>	<b>117.96</b>	<b>99.9</b>
210401	Бичиг хэрэг	3,690.90	3,690.90	0.00	100.0
210402	Тээвэр, шатахуун	70,631.60	70,518.09	113.51	99.8
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,243.40	2,238.95	4.45	99.8
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,672.00	11,672.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	600.00	600.00	0.00	100.0
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>9,700.00</b>	<b>9,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.0</b>
210604	Урсгал засвар	9,700.00	9,700.00	0.00	100.0
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,543.50</b>	<b>7,543.00</b>	<b>0.50</b>	<b>100.0</b>
210702	Дотоод албан томилолт	7,543.50	7,543.00	0.50	100.0
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>75,649.00</b>	<b>58,924.97</b>	<b>16,724.03</b>	<b>77.9</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	71,000.00	54,275.97	16,724.03	76.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500.00	500.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	27.00	27.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60.00	60.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,762.00	3,762.00	0.00	100.0
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	300.00	300.00	0.00	100.0
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>181,531.00</b>	<b>174,679.63</b>	<b>6,851.37</b>	<b>96.2</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	175,531.00	168,679.65	6,851.35	96.1
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,000.00	5,999.98	0.02	100.0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>35,669.60</b>	<b>4,328.00</b>	<b>31,341.60</b>	<b>12.1</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>35,669.60</b>	<b>4,328.00</b>	<b>31,341.60</b>	<b>12.1</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	31,339.60	0	31,339.60	0.0
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,330.00	4,328.00	2.00	100.0
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>593,752.80</b>	<b>494,707.98</b>	<b>99,044.82</b>	<b>83.3</b>
220001	Барилга байгууламж	593,752.80	494,707.98	99,044.82	83.3
<b>III</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,249,847.60</b>	<b>2,004,963.75</b>	<b>244,883.85</b>	<b>89.1</b>
<b>31</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>414,840.20</b>	<b>0</b>	<b>414,840.20</b>	<b>0.0</b>
310004	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих	414,840.20	0	414,840.20	0.0
<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1,669,094.80</b>	<b>1,937,227.89</b>	<b>-268,133.09</b>	<b>116.1</b>
320001	Орон нутгийн төсвөөс	1,669,094.80	1,533,007.59	136,087.21	91.8
320002	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	0	404,220.30	-404,220.30	
<b>35</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>165,912.60</b>	<b>67,735.85</b>	<b>98,176.75</b>	<b>40.8</b>
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	40,096.30	67,521.09	-27,424.79	168.4
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,000.00	214.76	785.24	21.5
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	124,816.30	0	124,816.30	0.0
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл□	0	124,816.31	-124,816.31	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл□	0	85,172.62	-85,172.62	

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
6	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	54	54		
61	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	2	2		
610001	Төсвийн байгууллага	2	2		
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	26	26		
620001	Удирдах ажилтан	10	10		
620002	Гүйцэтгэх ажилтан	11	12		
620003	Үйлчлэх ажилтан	3	3		
620004	Гэрээт ажилтан	2	1		
65	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	26	26		
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9	10		
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТУ)	6	6		
650010	Гэрээт ажилтан	2	1		
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	9	9		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>34,641.33</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>34,641.33</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>34,357.17</b>
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>600.00</b>
210402	Тээвэр, шатахуун	600.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>33,757.17</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	33,757.17
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>284.16</b>
2133	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>284.16</b>
213405	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	284.16
I	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>34,641.33</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>34,641.33</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,300.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,341.33

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Бууцагаан сум нь “Төрийн бодлогыг орон нутагт хэрэгжүүлэх, иргэдийн хууль ёсны эрх ашгийг хамгаалах, ардчилал шударга ёсыг тогтоох, хууль дээдлэх төрийн үйл ажиллагаа, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, олон талт арга хэмжээг хэрэгжүүлэх, ажил үйлчилгээг хөнгөн шуурхай жигд хүртээмжтэй явуулах, төсөв санхүүгийн хэмжээг тодорхойлох, эцсийн үр дүнг үнэлж, дүгнэх, нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх” гэсэн эрхэм зорилго дэвшүүлэн дараах зорилтыг тавин ажиллажээ. Үүнд:

- Хөдөө аж ахуйг хөгжүүлэх
- Газар тариаланг хөгжүүлэх
- Нийтийн аж ахуй, жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх
- Байгаль хамгаалах хөтөлбөр
- Сумын эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх
- Төрийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, сурталчлах, сургалт сурталчилгаа
- Сумын засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудыг хэрэгжүүлэх
- Монгол улсын Засгийн газраас Боловсрол Соёл, Эрүүл мэндийн салбарт хэрэгжиж буй дэд хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх
- Иргэдийн оролцоог хангах

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь 2018 онд аймгийн ЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтсээс гаргасан "Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3,008,430.2 мянган төгрөгөөр буюу 7.3 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл		Эцсийн үлдэгдэл		Өөрчлөлт	
	Дүн	Эзлэх хувь	Дүн	Эзлэх хувь	Дүн	Хувь
А	1	2	3	4	5	6
<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	662,196.8	23.6%	902,786.6	30.0%	240,589.7	36.3%
Мөнгөн хөрөнгө	321,800.7	11.5%	507,382.4	16.9%	185,581.7	57.7%
Авлага	190,821.7	6.8%	252,453.4	8.4%	61,631.7	32.3%
Урьдчилгаа	-	0.0%	-	0.0%	-	0.0%
Бараа материал	149,574.4	5.3%	142,950.7	4.8%	(6,623.7)	-4.4%
<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	2,142,505.8	76.4%	2,105,643.6	70.0%	(36,862.2)	-1.7%
Үндсэн хөрөнгө	5,591,471.2	199.4%	5,765,199.7	191.6%	173,728.5	3.1%
Хуримтлагдсан элэгдэл	(3,448,965.4)	-123.0%	(3,659,556.1)	-121.6%	(210,590.7)	6.1%
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,804,702.6</b>	<b>100.0%</b>	<b>3,008,430.2</b>	<b>100.0%</b>	<b>203,727.5</b>	<b>7.3%</b>
Өр төлбөр	6,575.2	0.2%	2,143.4	0.1%	(4,431.9)	-67.4%
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,798,127.4	99.8%	3,006,286.8	99.9%	208,159.4	7.4%
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,804,702.6</b>	<b>100.0%</b>	<b>3,008,430.2</b>	<b>100.0%</b>	<b>203,727.5</b>	<b>7.3%</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан нь мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгийн данс байна.

#### 3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 507,382.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 185,581.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ ДҮН</b>	<b>321,800.7</b>	<b>507,382.4</b>	<b>185,581.7</b>
31200	<b>Банканд байгаа бэлэн мөнгө</b>	<b>321,800.7</b>	<b>507,382.4</b>	<b>185,581.7</b>
31210	<b>Төгрөг</b>	<b>321,800.7</b>	<b>507,382.4</b>	<b>185,581.7</b>
31211	Төрийн сангийн харилцах	321,800.7	507,382.4	185,581.7

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 507,382.4 мянган төгрөг нь Орон нутгийн хөгжлийн сангийн дансанд 59,897.8 мянга, Хоршоог хөгжүүлэх сангийн

дансанд 25,274.8 мянга, орон нутгийн ерөнхий орлогын үлдэгдэл 422,209.8 мянган төгрөг байгаа нь тайлант оны татварын давсан орлого 338,091.4 мянга, төсөвт байгууллагуудын буцаан төвлөрүүлсэн 84,118.4 мянган төгрөг байна.

### 3.5.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 252,443.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 61,631.7 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү	Өсөлт (+), Бууралт (-)
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	741.9	742.4	0.5	0.3
<b>33520</b>	<b>Хувь хүмүүсээс авах авлага</b>	-	36,180.0	36,180.0	14.3
<b>336</b>	<b>Зээлийн авлага</b>	190,069.8	215,521.1	25,451.3	85.4
	<b>Дүн</b>	<b>190,811.7</b>	<b>252,443.4</b>	<b>61,631.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд авлага дансны үлдэгдэл өссөн шалтгаан нь хоршоо хөгжүүлэх сангаас 7 зээлдэгчид 81,000.0 мянган төгрөгийн зээлийг олгосон, мөн ЗДТГ-үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 36,180.0 мянган төгрөгийн моторыг данснаас хасаж авлагаар тусгасантай холбоотой байна.

Хүснэгт 4. Авлагын үлдэгдэл /байгууллагаар/

/мянган төгрөгөөр/

Байгууллагуудын нэр	Авлагын эхний үлдэгдэл	Авлагын эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	717.9	717.9	(0.0)	0.3
Засаг даргын тамгын газар	34.0	36,214.5	36,180.5	14.3
Хоршоо хөгжүүлэх сан	190,069.8	215,521.1	25,451.3	85.4
<b>НИЙТ ДҮН</b>	<b>190,821.7</b>	<b>252,453.4</b>	<b>61,631.7</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Нийт авлагын 85.4 хувь буюу 215,521.1 мянган төгрөгийг хоршоо хөгжүүлэх сангийн авлага, 14.3 хувь буюу 36,214.5 мянган төгрөгийг сумын ЗДТГ-ын хувь хүнээс авах авлага эзэлж байна.

### 3.5.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 142,950.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 6,623.7 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Мал амьтад	11,000.0	40,577.4	29,577.4	28.4
Бичиг хэргийн материал	4,154.8	4,417.3	262.5	3.1
Аж ахуйн материал	1,852.9	-	(1,852.9)	-
Түлш, шатах тослох материал	300.0	300.0	-	0.2
Барилгын засварын материал	4,392.0	8,892.0	4,500.0	6.2
Бусад хангамжийн материал	123,974.7	75,069.0	(48,905.7)	52.5
<b>Дүн</b>	<b>149,574.4</b>	<b>142,950.7</b>	<b>(6,623.7)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Бараа материалын дансны үлдэгдэл 142,950.7 мянган төгрөг болж өмнөх оноос 6,623.7 мянган төгрөгөөр буурсан нь сумын ЗДТГ 216,684.2 мянга, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал 12,713.9 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь голлох нөлөө үзүүлж байна.

Хүснэгт 6. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Бараа материалын орлого, зарлагын үзүүлэлт	Дүн
<b>2023 оны эхний үлдэгдэл</b>	<b>149,574.4</b>
<b>Нэмэгдсэн</b>	<b>229,398.1</b>
Худалдан авсан	148,491.6
Шилжүүлэн авсан	79,053.6
Бусад	1,852.9

<b>Хасагдсан</b>	<b>236,021.8</b>
Худалдсан, зарцуулсан	174,222.9
Шилжүүлсэн	1,852.9
Бусад	59,946.0
<b>2023 оны эцсийн үлдэгдэл</b>	<b>142,950.7</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нийт нэмэгдсэн 229,398.1 мянган төгрөгийн бараа материалын 148,491.6 мянган төгрөгийн хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 79,053.6 мянган төгрөгийн хөрөнгө нь сумын ЗДТГ-т, 1852.9 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-д үнэ төлбөргүй шилжүүлэн авч бүртгэсэн байна.

### 3.5.6 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 5,765,199.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 173,728.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
<b>БИЕТ ХӨРӨНГӨ</b>	<b>5,559,493.2</b>	<b>5,733,221.7</b>	<b>173,728.5</b>	<b>99.4</b>
Барилга байгууламж, орон сууц	4,736,867.2	4,788,862.2	51,995.0	83.1
Тээврийн хэрэгсэл	290,330.5	277,350.5	(12,980.0)	4.8
Машин тоног төхөөрөмж	256,267.0	233,191.1	(23,075.9)	4.0
Тавилга эд хогшил	116,916.6	121,943.2	5,026.5	2.1
Зам гүүрний барилга	-	27,000.0	27,000.0	0.5
Түүх соёлын дурсгал	7,000.0	7,000.0	-	0.1
Бусад үндсэн хөрөнгө	152,111.8	277,874.7	125,762.9	4.8
<b>БИЕТ БУС ХӨРӨНГӨ</b>	<b>31,978.0</b>	<b>31,978.0</b>	<b>-</b>	<b>0.6</b>
Программ хангамж	13,978.0	13,978.0	-	0.2
Бусад биет бус хөрөнгө	18,000.0	18,000.0	-	0.3
	<b>5,591,471.2</b>	<b>5,765,199.7</b>	<b>173,728.5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,765,199.7 мянган төгрөг болж, өмнөх оноос 173,728.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн бөгөөд 279,693.9 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ЗДТГ-т шилжүүлэн авч бүртгэсэн нь нь голлох нөлөө үзүүлж байна

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагуудын нэрс	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Иргэдийн төлөөлөгчдийн хурал	38,919.0	36,217.0	(2,702.0)	0.6
Засаг даргын тамгын газар	5,552,552.2	5,728,982.7	176,430.5	99.4
<b>Салбарын нийт дүн</b>	<b>5,591,471.2</b>	<b>5,765,199.7</b>	<b>173,728.5</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант онд нэмэгдсэн 289,193.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн 95.7 хувь буюу 279,693.9 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна. Үүнд: аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн 13/11 дүгээр тогтоолоор 8,430.0 мянган төгрөгийн өртөг бүхий мотоцикл, 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн 17/64 дүгээр тогтоолоор 35105.5 мянган төгрөгийн өртөг бүхий худаг, аймгийн ИТХ-ын даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн 107 дугаар захирамжаар 32,580.0 мянган төгрөгийн өртөг бүхий мотоцикл болон замын бордюр, сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/200 дугаар захирамжаар сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар бий болсон 179,664.4 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, аймгийн ИТХ-ын хуралдааны 2023 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн 16/49 дугаар тогтоолоор 25,593.3 мянган төгрөгийн балансын үнэ

бүхий тавилга эд хогшил, тоног төхөөрөмжийг данснаас хасах шийдвэр гарсны дагуу акталж, мөн аймгийн Орон нутгийн өмчийн газрын шийдвэрээр 31,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий автомашиныг дуудлага худалдаагаар худалдаж, аймгийн ИТХ-ын төлөөлөгчдийн хурлын даргын 2023 оны 07 дугаар сарын 28-ны өдрийн 67 дугаар захирамжаар аймгийн Мал эмнэлгийн газарт 19,990.0 мянган төгрөгийн автомашиныг шилжүүлж, мөн орон нутгийн өмчийн тооллогоор дутагдсан 36,180.0 мянган төгрөгийн өртөг бүхий дизель моторыг данс бүртгэлээс хассан байна.

Хүснэгт 9. Үндсэн хөрөнгө

/мянган төгрөгөөр/

<b>2023 оны эхний үлдэгдэл</b>	<b>5,591,471.2</b>
<b>Нэмэгдсэн</b>	<b>289,193.8</b>
Худалдан авсан	9,499.9
Шилжүүлэн авсан	279,693.9
<b>Хасагдсан</b>	<b>115,465.3</b>
Худалдсан	31,000.0
Акталсан	28,295.3
Шилжүүлсэн	19,990.0
Бусад	36,180.0
<b>2023 оны эцсийн үлдэгдэл</b>	<b>5,765,199.7</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

### 3.5.7 Өр төлбөр

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 2,143.4 мянган төгрөг болж, өмнөх оноос 4,431.9 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 10. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>6,575.2</b>	<b>2,143.4</b>	<b>(4,431.9)</b>	<b>100.0</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	5.1	-	(5.1)	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	6,570.1	1,643.4	(4,926.8)	76.7
41361	Байгууллагад төлөх өглөг	-	500.0	500.0	23.3
	<b>Дүн</b>	<b>6,575.2</b>	<b>2,143.4</b>	<b>(4,431.9)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Богино хугацаат өр төлбөр нь 2,143.4 мянган төгрөгийн үлдэгдэлтэй бөгөөд үүнд ЗДТГ-ын өмнөх оноос үүссэн 1,643.6 мянга, бэлтгэн нийлүүлэгч байгууллагад 500.0 мянган төгрөгийн өглөгийг төлж барагдуулаагүйтэй холбоотой байна.

Хүснэгт 11. Өглөгийн дансны үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Д.д	Байгууллагуудын нэр	Өглөгийн эхний үлдэгдэл	Өглөгийн эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
1	Иргэдийн төлөөлөгчдийн хурал	3,729.4		(3,729.4)	-
2	Засаг даргын тамгын газар	2,845.9	2,143.4	(702.5)	100.0
	<b>ТШЗ-ийн байгууллагын ДҮН</b>	<b>6,575.3</b>	<b>2,143.4</b>	<b>(4,431.9)</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

### 3.5.10 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 3,006,286.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 208,159.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 11. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөгөөр/

Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)	Хувь
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	537,862.8	537,862.8	-	17.9
Өмч: - төрийн	537,862.8	537,862.8	-	17.9
<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,840,901.5</b>	<b>2,049,096.4</b>	<b>208,194.9</b>	<b>68.2</b>
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	419,363.1	419,327.6	(35.5)	13.9
<b>Дүн</b>	<b>2,798,127.4</b>	<b>3,006,286.8</b>	<b>208,159.4</b>	<b>100.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл үлдэгдэл 3,006,286.8 мянган төгрөг болж, өмнөх оноос 208,159.4 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээр өссөнтэй холбоотой байна.

### 3.5.11 Орлогын данс

Сумын ИТХ-ын 2022.12.15-ний өдрийн хуралдаанаар 8/06 дүгээр тогтоолоор сумын төсвийн татварын орлогыг 401,924 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 341,950.6 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 26,000.0 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 915,923.2 мянга, урд оны үлдэгдлийг 272,666.0 мянга нийт 1,958,463.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.06-ны өдрийн 11/01 дүгээр тодотгосон тогтоолоор татварын орлогыг 412,154 мянга, татварын бус орлогыг 30,000.0 мянга, ОНХС-ийн шилжүүлгийг 414,840.2 мянга, аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгийг 1,037,166.8 мянга, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 41,096.3 мянга, урд оны үлдэгдлийг 314,590.3 мянга нийт 2,249,847.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Хүснэгт 12. Орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>1.Татварын орлого</b>	412,154.0	637,392.6	231,731.3	154.6
1.1. ЦХТАО /суутган-1/	198,330.0	250,234.8	51,904.8	126.2
1.2.ИОТХ	17,000.0	25,919.6	8,919.6	152.5
1.3. Хадгаламжийн хүүгийн орлого	41,000.0	46,258.2	5,258.2	112.8
1.4. Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар	4,000.0	3,601.2	(398.8)	90.0
1.5.Бууны татвар	2,580.0	2,280.0	(300.0)	88.4
1.6.Улсын тэмдэгтийн хураамж	3,500.0	11,062.5	7,562.5	316.1
1.7. Газрын төлбөр	6,500.0	6,907.2	407.2	106.3
1.8.Ан агнуурын нөөц ашигласны төлбөр	14,144.0	203,008.9	188,864.9	1,435.3
1.9. Хог хаягдлын үйлчилгээний төлбөр	13,900.0	21,248.5	7,348.5	152.9
1.10. ТТАМАТөлбөр	600.0	-	(600.0)	-
1.11. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	1,400.0	1,691.5	291.5	120.8
1.12. Малын тоо толгойн албан татвар	102,000.0	64,472.9	(37,527.1)	63.2
1.13 Газрын дуудлага худалдаа	7,200.0	-	(7,200.0)	-
1.14 Ус рашаан ашигласны төлбөр	-	707.3	707.3	
<b>2.Татварын бус орлого</b>	30,000.0	83,534.4	7,120.0	278.4
2.1.Хүү торгуулийн орлого	30,000.0	83,534.4	7,120.0	278.4
<b>Нийт дүн</b>	<b>442,154.0</b>	<b>720,927.0</b>	<b>238,851.3</b>	<b>163.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын ИТХ-ын тогтоол

Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг 225,238.6 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн ч орлогын нэр төрлөөр авч үзвэл үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 398.8 мянга, бууны татвар 300.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малын тоо толгойн албан татварыг 37,527.1 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмал 600.0 мянга, нийт 46,025.9 мянган төгрөгөөр тус тус тасарсан байна.

### 3.5.12 Зардлын данс

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 70105, 70106, 70503, 71602, 71801, 71802, 72101, 71702 гэсэн кодтой 8 хөтөлбөрт зориулан 2,249,847.6 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 2,044,607.4 мянган төгрөгийг гүйцэтгэлээр зарцуулснаас 1,549,899.5 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулсан бол 494,708.0 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулсан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус төвлөрүүлэн захирагчийн харьяаны 2 төсвийн байгууллага төсвийн төслийг бэлтгэж, аймгийн СТСХ-т хүргүүлсэн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022.12.15-ний өдрийн 8/06 дугаар тогтоолоор нийт 1,958,463.8 мянган төгрөгийг баталсан байна.

Хүснэгт 13. Төсвийн төлөвлөлт

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	Төсвийн төсөл	Анх батлагдсан төсөв	Зөрүү
Иргэдийн төлөөлөгчдийн хурал		81,608.7	81,608.7
Засаг даргын Тамгын газар	829,723.8	560,452.1	(269,271.7)
Сумын сургууль, цэцэрлэг, соёл		662,286.4	662,286.4
Байгаль хамгаалах сан		70,000.0	70,000.0
СХСан		80,000.0	80,000.0
ОНХСан		504,116.6	504,116.6
<b>Нийт дүн</b>	<b>829,723.8</b>	<b>1,958,463.8</b>	<b>1,128,740.0</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын ИТХ-ын тогтоол

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 8 хөтөлбөрийн арга хэмжээний зардалд сумын ИТХ-ын 2022.12.15-ны өдрийн 8/06 дүгээр тогтоолоор анх 1,958,463.8 мянган төгрөгөөр баталсан бөгөөд 2023.07.06-ны өдрийн 11/01 дугаар тогтоолоор 2,249,847.6 мянган төгрөгөөр баталсан байна.

Нийт зардлын 442,154.0 мянган төгрөгийг татварын болон татварын бус орлогоор, 414,840.2 мянган төгрөгийг орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох санхүүжилтээс, 1,037,166.8 мянган төгрөгийг аймгийн төсвөөс олгох санхүүгийн дэмжлэгээр, 41,096.3 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос, урьд оны үлдэгдлээс 314,590.3 мянган төгрөгийг тус тус санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 1,037,166.8 мянга, ОНХС-аас 404,220.3 мянга, төсөв байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 67,735.9 мянган төгрөгийн санхүүжилт авч 84,118.4 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

Хүснэгт 14. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,249,847.6</b>	<b>2,044,607.4</b>	<b>178,290.7</b>	<b>90.9</b>
<b>70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага</b>	<b>106,957.6</b>	<b>106,877.5</b>	<b>80.1</b>	<b>99.9</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	106,457.6	106,377.5	80.1	99.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	500.0	-	100.0
<b>70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>790,306.3</b>	<b>735,849.5</b>	<b>54,456.8</b>	<b>93.1</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	481,007.6	474,628.0	6,379.6	98.7
80106 Баг, хорооны ҮАЗардал	113,573.1	113,562.8	10.3	100.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	34,569.6	3,228.0	31,341.6	9.3
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	79,484.0	79,482.7	1.3	100.0
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	70,000.0	53,276.0	16,724.0	76.1
82212 Хур хог хаягдал, орчны божирдл	11,672.0	11,672.0	-	100.0
<b>70503 Орон нутгийн зорилтот ХОруулал</b>	<b>593,752.8</b>	<b>494,707.7</b>	<b>99,045.1</b>	<b>83.3</b>
80904 Нийгмийн зориулалттай барилга	76,912.6	76,912.6	-	100.0
83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	358,499.3	314,238.4	44,260.9	87.7
83402 ОНХС-Хайгуулын тусгай зөвшөөрөл	3,557.0	3,557.0	-	100.0
73403 ОНХС Ашиглалтын тусгай зөвшөөрөл	184.3	184.3	-	100.0
83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	102,000.0	47,215.8	54,784.2	46.3
83406 ОНХС - Бусад	52,599.6	52,599.6	-	100.0
<b>71602 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</b>	<b>98,710.5</b>	<b>96,386.5</b>	<b>2,324.0</b>	<b>97.6</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	98,710.5	96,386.5	2,324.0	97.6
<b>71801 Сургуулийн өмнөх боловсрол</b>	<b>80,708.1</b>	<b>66,122.6</b>	<b>14,585.5</b>	<b>81.9</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	80,708.1	66,122.6	14,585.5	81.9
<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>411,946.3</b>	<b>410,997.1</b>	<b>949.2</b>	<b>99.8</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	411,946.3	410,997.1	949.2	99.8
<b>72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих</b>	<b>88,000.0</b>	<b>81,150.0</b>	<b>6,850.0</b>	<b>92.2</b>
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	88,000.0	81,150.0	6,850.0	92.2
<b>71702 Соёл урлаг</b>	<b>79,466.00</b>	<b>52,516.50</b>	<b>26,949.5</b>	<b>66.1</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	79,466.00	52,516.50	26,949.5	66.1

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн тайлан

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган төгрөг буюу 90.9 хувьтай байгаа нь ЗДТГ-ын төсвийг 54,456.8 мянга, ИТХ-ын төсвийг 80.1 мянга, Ерөнхий боловсролын сургуулийн урсгал зардлыг 949.2 мянга, сургуулийн өмнөх боловсролын зардал 14,585.5 мянга, Эрүүл мэндийн төвийн төсвийг 2,324.0 мянга, соёлын төвийн төсвийг 26,949.5 мянган төгрөгөөр тус тус зарцуулаагүй нь голлох нөлөөг үзүүлж байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд дээд шатны төсвийн захирагчаас хуваарилсан 1,300.0 мянга, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогоор 33,341.3 мянган төгрөгийн санхүүжилтийг олгож, хангамж бараа материалын зардалд 600.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөрт 33,757.2 мянган төгрөгийг зарцуулж, 284.1 мянган төгрөгийн орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Үзүүлэлт	ЗДТГ	ИТХ	Нийт
<b>Нийт нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>33,341.3</b>	<b>1,300.0</b>	<b>34,641.3</b>
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		1,300.0	1,300.0
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	33,341.3		33,341.3
<b>НИЙТ ЗАРЛАГА</b>	<b>33,339.2</b>	<b>1,018.0</b>	<b>33,757.2</b>
Хангамж, бараа материалын зардал	600.0		
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр	32,739.2	1,018.0	33,757.2
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	-	-	-
<b>ТӨВЛӨРҮҮЛСЭН</b>	<b>2.1</b>	<b>282.0</b>	<b>284.1</b>

Эх сурвалж: Бууцагаан сумын санхүүгийн нэгтгэсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Сумын засаг даргын нөөц санг 79,484.0 мянган төгрөгийг баталж, гүйцэтгэлээр 79,482.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Тус байгууллагын 2022 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ж.Өсөхбаяр санхүүгийн тайлангийн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Сумын засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 7 бүлэг, 16 зорилго, 149 зорилттойгоор төлөвлөж, дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжилтийг 86.1 хувийн гүйцэтгэлтэй үнэлжээ.

### 3.5.5 Аудитын гол асуудал

Бууцагаан сумын Засаг даргын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн 2023 оны биелэлтийг 94.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Тус сум нь 14 нэр төрлийн орлогоор 442,154.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 720,927.0 мянган төгрөгийг төвлөрүүлж, нийт орлого 161.3 хувьтай биелсэн байна.

Сумын ТЭЗ-ийн харьяа байгууллагуудын аудитын явцад хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж, гаргалаа.

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяалагдах 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэн байна.

Төрийн аудитын байгууллагаас Бууцагаан сумын Засаг даргын харьяа байгууллагад аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Байгууллагын нэр	Байгууллагын тоо				Аудитын санал дүгнэлтийн төрөл				
	Хамрагдвал зохих	Хамрагдсан	Гүйцэтгэсэн		Бүгд	Үүнээс			
			Бие дааж дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан		Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Санал дүгнэлт өгөхөөс татгалзсан
ЗДТГ	1	1	1					1	
ИТХурал	1	1		1					
ОНХС	1	1		1					
СХС	1	1		1					
<b>НИЙТ ДҮН</b>	<b>4</b>	<b>4</b>	<b>1</b>	<b>3</b>				<b>1</b>	

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

Сумын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 2 төсвийн байгууллага, 2 тусгай сангийн нийт 4 санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 3 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Сумын ТЕЗ-ийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 120,989.0 мянган төгрөгийн 6 алдаа<sup>1</sup> илэрснийг санхүүгийн тайланд залруулсан байна.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган

төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
							Тоо	Дүн	Тоо	Дүн
Сумын ЗДТГ	4	117,904.0	2	78,634.6	2	39,269.4	4	117,904.0		
Сумын ИТХ	1	85.0			1	85.0	1	85.0		
Сумын ОНХС	1	3,000.0	1	3,000.0			1	3,000.0		
<b>Дүн</b>	<b>6</b>	<b>120,989.0</b>	<b>3</b>	<b>81,634.6</b>	<b>3</b>	<b>39,354.4</b>	<b>6</b>	<b>120,989.0</b>		

Нийт илэрсэн зөрчлөөс санхүүгийн тайлангийн 418,426.3 мянга, нийцлийн аудитын асуудалтай холбоотой 68,629.6 мянган төгрөгийн зөрчил илэрчээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №17. Төсвийн шууд захирагчийн алдаа зөрчлийн дүн

Байгууллагын нэр	Нийт алдаа зөрчлийн дүн		Залруулга		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Санхүүгийн тайлангийн зөрчил</b>										
ЗДТГ	17	371,573.5	4	117,904.0	4	7,056.4	8	210,037.6	1	36,575.5
ИТХ	3	38,872.8	1	85.0	1	717.9	1	38,069.9		
ОНХС	3	7,980.0	1	3,000.0	2	4,980.0				
<b>СТА зөрчлийн дүн</b>	<b>23</b>	<b>418,426.3</b>	<b>6</b>	<b>120,989.0</b>	<b>7</b>	<b>12,754.3</b>	<b>9</b>	<b>248,107.5</b>	<b>1</b>	<b>36,575.5</b>
<b>СТА-аар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>										
ЗДТГ	2	68,629.6					1	7,998.0	1	60,631.6
<b>Нийцлийн аудитын дүн</b>	<b>2</b>	<b>68,629.6</b>					<b>1</b>	<b>7,998.0</b>	<b>1</b>	<b>60,631.6</b>
<b>Нийт дүн</b>	<b>25</b>	<b>487,055.9</b>	<b>6</b>	<b>120,989.0</b>	<b>7</b>	<b>12,754.3</b>	<b>10</b>	<b>256,105.5</b>	<b>2</b>	<b>97,207.1</b>

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн зөрчлийг хүснэгтээр дэлгэрэнгүй харуулбал:

Хүснэгт 18: Харьяа байгууллагуудын аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
A	1	2	3	4	5
<b>Харьяа төсвийн байгууллагуудын дүн</b>		<b>366,066.9</b>			
<b>Засаг даргын тамгын газар</b>		<b>322,299.1</b>			
<b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b>					
1	Бараа үйлчилгээний бусад зардлаас "Байгаль хамгаалъя" дэвжээ тэмцээнийг зардалд 340.0 мянга, шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374.5 мянган төгрөгийг албан үйлчилгээнээс бусад зориулалтаар зарцуулсан байна.	2,714.5	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
2	Засаг даргын нөөц хөрөнгөөс Хүрээмарал, Бөмбөгөр сумдын 100 жилийн ойд 1,100.0 мянга, Монгол түмний харвуул их наадамд 1,000.0 мянга, аймгийн Мал эмнэлгийн 100 жилийн ойд зориулж 1,100.0 мянга нийт 3,200.0 мянган төгрөгийг анхан шатны баримтгүй, зарцуулалтын тайланг гаргаагүй байна.	3,200.0	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
3	Тус сумын Засаг даргад шийдвэргүйгээр 4 дүгээр сард 526.1 мянган төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон, мөн Засаг дарга нь 2023.06.08-ны өдөр томилолтын хуудаст өөрөө өөрийгөө томилж, өөртөө шийдвэр гарган 112.0 мянган төгрөгийн томилолт мөнгийг авсан байна.	638.1	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
4	Тайлант хугацааны түлш халаалтын зардлаас 236.3 мянга, шуудан холбоо интернэтийн төлбөрөөс 34.6 мянган төгрөгийг тээврийн хэрэгслийн даатгалд, бараа үйлчилгээний бусад зардлаас 232.9 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг төлж зардлыг зориулалт бусаар зарцуулсан байна.	503.8	Төлбөрийн акт	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
5	Байгууллагын үндсэн үйл ажиллагаатай холбоотой буюу урьдчилан төлөвлөх боломжтой автомашины сэлбэг хэрэгслийг солиход зориулан нийт 3,580.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгслийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулсан байна.	3,580.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
6	Байгууллагын даргын 2023.12.11-ны өдрийн А/33 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комисс нь 129,805.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 12,153.5 мянган төгрөгийн эргэлтийн хөрөнгийг тоолоогүй байна.	141,959.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
7	Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь шинээр худалдан авсан 6,032.8 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэлд өмч хамгаалах зөвлөлийн дүгнэлт гаргаагүй байна.	6,032.8	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
8	Засаг даргын нөөц хөрөнгөөс байгууллагын нярвын дансаар 24,886,600 төгрөг, Баянбүрд багийн ойн үйл ажиллагаанд зарцуулахаар Хонгор ойл ХХК руу 1,001,800 төгрөг, дунд ангийн багш нарыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдах, туршлага судлах хүсэлт тавьсны дагуу иргэн У.Даваасамбуугийн дансанд 1,000,000 төгрөг, тамгын газрын авто машинуудын сэлбэг худалдан авахад 3,850,000 мянган төгрөгийн гүйлгээг хүчин төгөлдөр бус зарлагын баримтыг үндэслэн хийсэн байна.	30,738.4	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
9	Тус байгууллага нь тайлант оны 2,143.4 мянган төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байна.	2,143.4	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
10	Тус байгууллагын төсөвт хоолны хөнгөлөлтийг батлаагүй байхад байгууллагын даргын 2023.10.23-ны өдрийн Б/38 дугаар тушаалаар 36,575.5 мянган төгрөгийн хоолны хөнгөлөлтийг байгууллагын дотоод журмыг үндэслэн цалингийн хэмнэлтээс олгосон байна.	36,575.5	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
11	Засаг даргын нөөц хөрөнгөөс 2023 оны 11 дүгээр сард 13,695.0 мянган төгрөгийн өвс тэжээлийг Арслант	13,695.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга,	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг

Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
	хүлэг ХХК-иас авсан бөгөөд гэрээ байгуулаагүй, тус өвс тэжээлийг хүлээн авсан акт үйлдээгүй байна.			нягтлан бодогч	
12	Бууцагаан аймгийн Засаг даргын 2023.10.17-ны өдрийн А/557 дугаар захирамжаар аймгийн Онцгой комиссоос нэг бүр нь 20.0 мянган төгрөгийн өртөг бүхий 100ш урьдчилан сэргийлэх эмчилгээний багц, аймгийн Сум дундын ойн ангиас хуваарилсан 5,889.0 мянган төгрөгийн өртөг бүхий тэжээлийг санхүүгийн тайланд бүртгээгүй, тооцоо нийлж баталгаажуулаагүй байна.	7,889.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
13	Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотод болсон "Эрдэнэ засгийн хошуу"-ны түүх судалгааны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад Кафейна ХХК-аас нэг бүр нь 75.0 мянган төгрөгийн өртөг бүхий 40 хүний хоолны зардалд 3,000.0 мянган төгрөгийн зарцуулсан, мөн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг гадаад улсад туршлага судлах аялахад 1,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3, 15 дугаар зүйлийн 15.1.3, 15.2.3 дахь заалтуудыг зөрчиж байна.	4,000.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
	<b>Дүн</b>	<b>253,669.5</b>			
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал</b>					
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад хуулийн 6.4.3-д заасан "Тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл"-ийг байршуулаагүй байна.	60,361.6	Зөвлөмж	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
2	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 5,298.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, нэмэлт санхүүжилтийн данснаас 2,700.0 мянган төгрөгийн нэг төсөл арга хэмжээг гүйцэтгүүлэх гэрээг багийн засаг дарга нартай хийж, санхүүжилтийг хувь хүний данс руу шилжүүлсэн бөгөөд тус ажлыг хүлээн авсан акт үйлдээгүй, гүйцэтгэсэн ажлын тайлан байхгүй, тухайн ажил хийгдсэн талаар нотлох баримт байхгүй байна.	7,998.0	Албан шаардлага	ЗДТГ-ын дарга, нягтлан бодогч	Л.Бүрнээбаатар, А.Отгонцэцэг
	<b>Дүн</b>	<b>68,629.6</b>			
<b>Бууцагаан сумын ИТХ</b>		<b>38,787.8</b>			
<b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b>					
1	Цалингийн урьдчилгааны өмнөх оны үлдэгдэл 717.9 мянган төгрөгийг суутган тооцож барагдуулаагүй байна.	717.9	Төлбөрийн акт	ИТХ-ын нарийн бичгийн дарга	М.Сарантуяа, Д.Нямдолгор
2	Байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 1,852.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, 36,217.0 мянган төгрөгийн бараа материалыг 2023 оны жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийж баталгаажуулаагүй байна.	38,069.9	Албан шаардлага	ИТХ-ын нарийн бичгийн дарга	М.Сарантуяа, Д.Нямдолгор
	<b>Дүн</b>	<b>38,787.8</b>			
<b>Орон нутгийн хөгжлийн сан</b>		<b>4,980.0</b>			
<b>Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл</b>		<b>4,980.0</b>			
1	Нийтийн эзэмшлийн талбайн хог хаягдал зайлуулах, орчны бохирдол бууруулах зардлаас 2023.05.17-д "Элбэг саран" ХХК-д 1,980.0 мянган төгрөгийг шилжүүлж сумын ЗДТГ-т скайнер худалдан авсан байна.	1,980.0	Төлбөрийн акт	Засаг дарга, сан хариуцсан нягтлан бодогч	Д.Лхагвадорж, Д.Нямдолгор
2	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас сумын засаг даргын 2023.09.26-ны өдрийн А/140 дугаар захирамжаар Ахмадын өргөөнд 3,000.0 мянган төгрөгийн хөгжим худалдан авсан байна.	3,000.0	Төлбөрийн акт	Засаг дарга, сан хариуцсан нягтлан бодогч	Д.Лхагвадорж, Д.Нямдолгор
	<b>Дүн</b>	<b>4,980.0</b>			

Эх сурвалж: Төрийн аудитын байгууллагын зөрчлийн нэгтгэл

### 3.5.6 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 8 хөтөлбөрийн арга хэмжээг хэрэгжүүлэхээр нийт 2,249,847.6 мянган төгрөгийн төсөв баталж, гүйцэтгэлээр 2,044,607.4 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Аудитын код: БНА-2024/6/НА-СТА-ТТЗ

Хуудас-25

Хүснэгт 15. Төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,249,847.6</b>	<b>2,044,607.4</b>	<b>178,290.7</b>	<b>90.9</b>
<b>70105 ОН-ын өөрөө удирд ёсны байгууллага</b>	<b>106,957.6</b>	<b>106,877.5</b>	<b>80.1</b>	<b>99.9</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	106,457.6	106,377.5	80.1	99.9
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	500.0	500.0	-	100.0
<b>70106 ОН-ын гүйцэтгэх засаглалын удирдлага</b>	<b>790,306.3</b>	<b>735,849.5</b>	<b>54,456.8</b>	<b>93.1</b>
80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	481,007.6	474,628.0	6,379.6	98.7
80106 Баг, хорооны ҮАЗардал	113,573.1	113,562.8	10.3	100.0
80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж,	34,569.6	3,228.0	31,341.6	9.3
81102 Орон нутгийн нөөц хөрөнгө	79,484.0	79,482.7	1.3	100.0
81701 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх	70,000.0	53,276.0	16,724.0	76.1
82212 Хур хог хаягдал, орчны бохирдл	11,672.0	11,672.0	-	100.0
<b>70503 Орон нутгийн зорилтот ХОруулал</b>	<b>593,752.8</b>	<b>494,707.7</b>	<b>99,045.1</b>	<b>83.3</b>
80904 Нийгмийн зориулалттай барилга	76,912.6	76,912.6	-	100.0
83401 ОНХС - Итгэлцүүрээр олгох	358,499.3	314,238.4	44,260.9	87.7
83402 ОНХС-Хайгуулын тусгай зөвшөөрөл	3,557.0	3,557.0	-	100.0
73403 ОНХС Ашиглалтын тусгай зөвшөөрөл	184.3	184.3	-	100.0
83405 ОНХС - Малын тоо толгойн албан татвар	102,000.0	47,215.8	54,784.2	46.3
83406 ОНХС - Бусад	52,599.6	52,599.6	-	100.0
<b>71602 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ</b>	<b>98,710.5</b>	<b>96,386.5</b>	<b>2,324.0</b>	<b>97.6</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	98,710.5	96,386.5	2,324.0	97.6
<b>71801 Сургуулийн өмнөх боловсрол</b>	<b>80,708.1</b>	<b>66,122.6</b>	<b>14,585.5</b>	<b>81.9</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	80,708.1	66,122.6	14,585.5	81.9
<b>71802 Ерөнхий боловсрол</b>	<b>411,946.3</b>	<b>410,997.1</b>	<b>949.2</b>	<b>99.8</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	411,946.3	410,997.1	949.2	99.8
<b>72101 Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих</b>	<b>88,000.0</b>	<b>81,150.0</b>	<b>6,850.0</b>	<b>92.2</b>
82611 Жижиг дунд үйлдвэрийг дэмжих	88,000.0	81,150.0	6,850.0	92.2
<b>71702 Соёл урлаг</b>	<b>79,466.00</b>	<b>52,516.50</b>	<b>26,949.5</b>	<b>66.1</b>
80112 Нийтлэг үйлчилгээ	79,466.00	52,516.50	26,949.5	66.1

Эх сурвалж: Бууцагаан сумын Засаг даргын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Бууцагаан сумын Засаг даргын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Нарангэрэл гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 03-ний өдрийн 1/01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 2,082,266.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 31,234.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 21,863.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзээд шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайлангийн аудитаар “Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд: Сумын Засаг даргын Тамгын газар нь

1. Бараа үйлчилгээний бусад зардлаас "Байгаль хамгаалъя" дэвжээ тэмцээнийг зардалд 340.0 мянга, шатахууны зардлаас нутгийн золголт, уралдаан тэмцээн, туршлага солилцох зэрэгт 2,374.5 мянган төгрөгийг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2<sup>2</sup>, 15 дугаар зүйлийн 15.1.3<sup>3</sup>, 15.2.3<sup>4</sup> дахь заалтыг зөрчсөнд төлбөрийн акт тогтоосон.

2. Засаг даргын нөөц хөрөнгөөс Улаанбаатар хотод болсон "Эрдэнэ засгийн хошуу"-ны түүх судалгааны эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулахад Кафейна ХХК-аас нэг бүр нь 75.0 мянган төгрөгийн өртөг бүхий 40 хүний хоолны зардалд 3,000.0 мянган төгрөгийн зарцуулсан, мөн сумын хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгчийг гадаад улсад туршлага судлах аялахад 1,000.0 мянган төгрөгийн тус тус зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3<sup>5</sup>, 15 дугаар зүйлийн 15.1.3<sup>6</sup>, 15.2.3<sup>7</sup> дахь заалтыг зөрчсөн тул зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

## 4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

<sup>2</sup> Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга, аймаг, сум, баг, нийслэл, дүүргийн Засаг даргаас бусад этгээд албан тушаалын суудлын автомашин ашиглахыг хориглоно.

<sup>3</sup> хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох

<sup>4</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

<sup>5</sup> Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно.

<sup>6</sup> хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох;

<sup>7</sup> сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх;

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс сар бүр мэдээлэх мэдээллээс 9 мэдээлэл, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн хуулийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 81,000.0 мянган төгрөгийн 7 зээлийн гэрээ, 6.4.3-д заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 254,914.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж, мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хугацаанд нь бүрэн байршуулах албан шаардлагыг хүргүүлсэн.

#### 4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.7.1 Завсрын аудитын талаар

Тайлант хугацаан завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид зөрчлийг арилгах 27,453.4 мянган төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн ба хэрэгжилтийг сумын Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 1а/134 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

Хүснэгт 16. Өмнөх аудитаар өгсөн зөвлөмж

/ мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Биелэгдээгүй		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Албан шаардлага	3	27,453.4	3	27,453.4	0	0	100
<b>Нийт</b>	<b>3</b>	<b>27,453.4</b>	<b>3</b>	<b>27,453.4</b>	<b>0</b>	<b>0</b>	<b>100</b>

Эх сурвалж: Шийдвэрийн хэрэгжилт

#### 4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

байхгүй

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 393,176.4 мянган төгрөгийн 5 зөрчил<sup>8</sup> илэрсэнд 11,236.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 1 зөвлөмж, зөрчлийг арилгах 381,940.4 мянган төгрөгийн 2 албан шаардлага, хариуцлага тооцуулах 1 саналыг өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

**5.1.1 Илрүүлэлт:** Тус сумын хоршоо хөгжүүлэх сангаас зээл авсан 5 зээлдэгчийн 11,236.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн А/361 дүгээр тушаал "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3.4.5-д "Зээл, зээлийн хүүгийн орлогыг сангийн дансанд төвлөрүүлэх", 6.9. дахь "Хуулийн этгээд иргэн нь авсан зээл, зээлийн хүүг гэрээнд заасан хугацаанд сангийн дансанд буцаан төлнө" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Хууль тогтоомж, зээлийн гэрээний үүргээ зөрчиж, санд төвлөрүүлээгүй 11,236.0 мянган төгрөгийг хавсралтад заасан зээлдэгчдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 5.2 Албан шаардлага

**5.2.1 Илрүүлэлт:** Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 398.8 мянга, бууны татвар 300.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 37,527.1 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 600.0 мянган төгрөгөөр тасарсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.8<sup>9</sup>, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5.1.3<sup>10</sup> дахь заалт, мөн үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Сумын төсөвт төвлөрөх татварын орлогыг үндэслэлтэй төлөвлөж байх, төсөвт бүрэн төвлөрүүлэх албан шаардлагыг хүргүүлэв.

**5.2.2 Илрүүлэлт:** Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс сар бүр мэдээлэх мэдээллээс 9 мэдээлэл, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн хуулийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 81,000.0 мянган төгрөгийн 7 зээлийн гэрээ, 6.4.3-д заасан тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 254,914.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3 дахь "Тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан", 6.4.8 дахь "Бонд, зээл, өрийн бичиг,

<sup>8</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

<sup>9</sup> Сум, дүүргийн төсвийн татварын орлого дараах орлогоос бүрдэнэ

<sup>10</sup> жинхэнэ хэрэгжилтийн

баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр” гэсэн заалтуудыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.3, 6.4.8-д заасан мэдээллийг бүрэн байршуулж, зөрчлийг арилгах албан шаардлагыг хүргүүлэв.

5.2.3 Илрүүлэлт: Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар “Сөрөг” дүгнэлт авсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.7 “Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавих, хүрэх үр дүнг хангаж ажиллах” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын дарга Л.Бүрнээбаатарт хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах албан шаардлагыг хүргүүлэв.

### **5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### **1. Дотоод хяналт хариуцлагатай холбоотой асуудал**

Илрүүлэлт: Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 487,426.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 120,989.0 мянган төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж, 12,754.3 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 256,105.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 97,207.1 мянган төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14.2.10<sup>11</sup> дахь заалтыг зөрчсөн бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

#### **Өгсөн зөвлөмж:**

Харьяа төсөвт байгууллагуудын санхүү төсвийн үйл ажиллагаанд тавих хяналтыг сайжруулж, хариуцлагыг дээшлүүлэх, төсвийн сахилга батыг дээшлүүлж, өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод хяналтыг хэрэгжүүлж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

<sup>11</sup> өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.  
Аудитын код: БНА-2024/6/НА-СТА-ТТЗ

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/										
			Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бууцагаан сумын Засаг дарга	4	57,261.9	1	11,236.0	1	46,025.9	1	0	1	0			
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>57,261.9</b>	<b>1</b>	<b>11,236.0</b>	<b>1</b>	<b>46,025.9</b>	<b>1</b>	<b>0</b>	<b>1</b>	<b>0</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Байгууллагын нэр	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Бууцагаан сумын Засаг дарга	1	335,914.5			1	335,914.5			
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>335,914.5</b>			<b>1</b>	<b>335,914.5</b>			

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/						
			Үүнээс						
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Тус сумын сум хөгжүүлэх сангаас зээл авсан 5 зээлдэгчийн 11,236.0 мянган төгрөгийн зээл хугацаа хэтэрсэн ч хууль хяналтын байгууллагад шилжүүлээгүй байна.	1	11,236.0	1	11,236.0					
Бууцагаан сумын Засаг даргын Тамгын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар "Сөрөг" дүгнэлт авсан байна.	1	0			1	0			
Бууцагаан сумын Засаг даргын харьяа төсвийн шууд захирагчийн байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул байгаагаас нийт 487,426.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 120,989.0 мянган төгрөгийн 6 алдааг санхүүгийн тайланд залруулж, 12,754.3 мянган төгрөгийн 7 төлбөрийн акт тогтоож, 256,105.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 10 албан шаардлага, алдаа зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 97,207.1 мянган	1	0						1	0

төгрөгийн 2 зөвлөмжийг хүргүүлсэн байна.								
Сумын төсөвт төвлөрөх татварын орлогоос үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны албан татвар 398.8 мянга, бууны татвар 300.0 мянга, газрын дуудлага худалдааны орлого 7,200.0 мянга, малын тоо толгойн албан татварын орлого 37,527.1 мянга, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 600.0 мянган төгрөгөөр тасарсан байна.	1	46,025.9			1	46,025.9		
<b>Дүн</b>	<b>4</b>	<b>57,261.9</b>	<b>1</b>	<b>11,236.0</b>	<b>2</b>	<b>46,025.9</b>	<b>1</b>	<b>0</b>

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуультай холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 155 мэдээллээс сар бүр мэдээлэх мэдээллээс 9 мэдээлэл, хагас жилд нэг удаа мэдээлэх мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроосон, мөн хуулийн 6.4.8-д заасан төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах шийдвэртэй холбоотой хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 81,000.0 мянган төгрөгийн 7 зээлийн гэрээ, 6.4.3-д заасан тендэрт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх 254,914.5 мянган төгрөгийн 4 мэдээллийг тус тус мэдээлээгүй байна.	1	335,914.5			1	335,914.5		
	1	335,914.5			1	335,914.5		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>335,914.5</b>			<b>1</b>	<b>335,914.5</b>		